



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн сүрье  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatassembly@parliament.mn  
<http://www.parliament.mn>

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙД ЛУВСАННАМСРАЙН  
ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

2023.08.15 № 24

Улаанбаатар хотын утаа болон  
сайжруулсан шахмал түлшний талаар

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар "Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах тухай" шийдвэр гарч, баруун ба зүүн бүсийн үйлдвэрүүдийг ашиглалтанд оруулж, уг үйлдвэр нь Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгжээр хүртэл шалгартал маш их хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн билээ. Гэвч бодит байдал дээр уг түлшний олдоц муюу, шаталт тааруу, угаартах эрсдэл өндөртэй байна гэх олон нийтийн шүүмжлэл цаг үргэлж дагасаар ирсэн. Үүнийг батлах мэт энэ өвөл 177.5 тэрбум төгрөгөөр коксжсон нүурс импортлон оруулж ирэх тухай асуудлыг Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын түвшинд яригдаж эхэлсэн нь олны нийтийн анхаарлыг татаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Дарга Монгол Улсын Ерөнхий сайд Танд Улаанбаатар хотын утаа, сайжруулсан шахмал түлштэй холбоотой дараах асуултлыг тавьж байна. Үүнд:

1. Улаанбаатар хотын утааны нехцел байдлын талаар;
2. Утааг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, тэдгээрт зарцуулагдсан төсөв, хөрөнгө оруулалт, татаас болон тэдгээрийн эх үүсвэрийн талаар;
3. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулснаар утаа буурсан эсэх тухай болон энэ хугацаанд угаартаж амиа алдсан болон эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан иргэдийн талаар;
4. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн тесөлд улсын болон орон нутгийн тесвееэс оруулсан хөрөнгө оруулалт, зарцуулсан зардал, түүний задаргаа;
5. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг цаашид хэрхэн ажиллуулах тухай болон түүний үр ашиг, нөлөөний талаар;
6. Импортлон оруулж ирэх гэж буй коксжсон нүурсэнд зарцуулагдах мөнгө, түүний задаргааны талаар;
7. Импортлох тулшийг иргэдэд борлуулах, түгээх схемийн талаар;

8. Импортлох түлшний нийлүүлэгч, техникийн үзүүлэлтүүд болон ахуйн нөхцөлд туршсан туршилт, мэргэжлийн байгууллагын өгч буй дүгнэлтийн талаар зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

2023000037